



УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/117

Улаанбаатар хот

Ажлын хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын гудамж, талбайн цэвэрлэгээ, арчилгаа, хамгаалалтын ажилд байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг гэрээгээр оролцуулах журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1, 2.4, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэл, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн сэргээлтийн ажлыг гэрээгээр хариуцан ажиллаж байгаа “Голден гарден” ХХК, “Таримал загийн төгөл” ХХК-ниас гаргасан хүсэлтийн дагуу Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/27 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын “Баянгол дүүрэг” гэсэн хэсэг дэх Цамбагаравын уулзвараас Барилгачны гудамжны уулзвар хүртэл автозамын урд талын болон автозамын голын бульварын мод, сөөг, зүлэгний арчилгааг хариуцсан “Таримал загийн төгөл” ХХК-нд “Чингэлтэй дүүрэг” гэсэн хэсэг дэхь Асашёрюгийн цэцэрлэгийг, “Таримал загийн төгөл” ХХК-ний хариуцаж байсан Цамбагаравын уулзвараас Барилгачны гудамжны уулзвар хүртэл автозамын урд талын болон автозамын голын бульварыг “Голден гарден” ХХК-нд тус тус хариуцуулсугай.


2. Дээрх байгууллагуудын гэрээг шинэчлэн байгуулж, өдөр тутмын ажилд нь Төрийн бус байгууллагатай хамтран хяналт тавьж, мэргэжлийн арга зүйн зөвөлгөө өгч ажиллахыг Төхижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр /-т үүрэг болгосугай.

3. Асашёрюүгийн цэцэрлэгийг хариуцаж байсан “Чингэлтэй тохижилт” ХХК хотын гудамж, цэцэрлэгийн мод, сөөгний хэлбэржүүлэлтийн ажил дагнан гүйцэтгэх хүсэлт гаргасан учир хүсэлтийнх нь дагуу Асашёрюүгийн цэцэрлэгийн арчилгааны ажлын 2019 оны 19/06-77 дугаар гэрээг хүчингүй болгосугай.

4. “Таримал загийн төгөл” ХХК, “Голден гарден” ХХК-тай байгуулсан 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 19/06-67, 19/06-69 дүгээр гэрээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Шинэчлэгдсэн гэрээний дагуу санхүүжилтийг гүйцэтгэлээр олгож ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/27 дугаар тушаалд өөрчлөлт орсонд тооцсугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

